ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Дорнод аймгийн Халхгол Сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2025/082/НА-СТА-ТШ3**


Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК
Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг
Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № 21
танай 2025.01.24-ны № 6-т

ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.УРАНТОГОС ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Халхгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд ажилтны цалинг 840.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, ажилтанд цалин дутуу олгосон, 103,317.3 мянган төгрөгийн худалдан авалтын төлөвлөгөө батлаагүй, үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй маягт бөглөөгүй, гэрээнд нийлүүлэх бүтээгдэхүүний жагсаалт хавсаргаагүй, гэрээг дүгнэж акт үйлдээгүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно, 39.3.2-т Гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл, 48 дугаар зүйлийн 48.2.9-т Энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа

011022135

удирдах заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Тайлант жилд нийгмийн даатгалын систем шинэчлэгдэж, төрийн алба хаагчдын цалингийн нэгдсэн системд ажил мэргэжлийн код болон даатгуулагчийн кодыг зөрүүтэй оруулснаас ажилтнаас илүү дутуу шимтгэл суутгах, байгууллагаас төлөх шимтгэлийн хэмжээг илүү дутуу тооцоолсноос шалтгаалан жилийн эцэст авлага, өр төлбөр үүсэж тайланд залруулгууд хийгдсэн байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Дорнод аймгийн Халхгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 5 зорилт, 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Боловсролын газраас 80.0 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **243,900,317.43** | **368,627,271.68** |
| **31211** | **Төрийн сангийн харилцах** | 112,758,177.89 | 238,801,703.48 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **131,142,139.54** | **129,825,568.20** |
| **351** | **Түүхий эд материал** | 31,059,761.10 | 30,850,838.10 |
| 35110 | Тусгай зориулалтын материал | 30,499,761.10 | 30,290,838.10 |
| 35130 | Эм боох материал | 560,000.00 | 560,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 100,082,378.44 | 98,974,730.10 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 295,200.00 | 371,700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 88,112,425.37 | 88,100,702.03 |
| 35460 | Хүнсний материал | 1,172,425.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 10,502,328.07 | 10,502,328.07 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **8,147,217,698.09** | **8,003,807,954.26** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 8,477,702,484.00 | 8,477,702,484.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (678,216,198.72) | (847,770,248.40) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 232,681,309.30 | 392,326,069.30 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (118,664,689.81) | (135,430,746.93) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 174,078,499.29 | 198,929,183.89 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (92,579,106.97) | (104,164,188.60) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 20,000,000.00 |
| 39217 | Номын фонд | 2,215,401.00 | 2,215,401.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 150,000,000.00 | |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **8,391,118,015.52** | **8372435225,94** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | 21,352,100.00 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | 21,352,100.00 |
| **413** | **Өглөг** | | 21,352,100.00 |
| 41312 | НДШ-ийн өглөг | | 201,600.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 21,160,500.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **8,391,118,015.52** | **8,351,073,125.94** |
| 51101 | Өмч: - төрийн | 521,977,813.50 | 521,977,813.50 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 6,442,943,869.51 | 6,402,898,979.93 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 7,210,124,022.25 | 6,442,943,869.51 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (767,180,152.74) | (40,044,889.58) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,426,196,332.51 | 1,426,196,332.51 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **8,391,118,015.52** | **8,372,435,225.94** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,243,354,456.10** | **2,210,358,422.60** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12,584,156.10** | **197,732,922.60** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **12,584,156.10** | **197,732,922.60** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 10,212,348.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 2,928,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | | 7,284,348.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 2,986,600.00 | 181,682,184.60 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 9,597,556.10 | 5,838,390.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,230,770,300.00** | **2,012,625,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,032,603,600.00 | 1,671,046,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 14,252,100.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,459,100.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 7,793,000.00 | |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/ | 183,914,600.00 | 341,578,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,442,480,132.44** | **2,093,968,330.18** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,442,480,132.44** | **2,093,968,330.18** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,389,350,457.56 | 2,044,702,168.67 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 791,456,356.86 | 1,224,363,397.53 |
| 210101 | Үндсэн цалин | 572,991,482.34 | 783,533,953.28 |
| 210102 | Нэмэгдэл | 182,963,416.52 | 393,067,285.68 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 35,501,458.00 | 47,762,158.57 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **100,173,519.46** | **153,072,240.73** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 69,100,713.18 | 104,433,039.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,036,769.40 | 12,242,480.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,559,016.22 | 6,019,719.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,537,397.47 | 6,049,803.78 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,939,623.19 | 24,327,197.67 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **175,541,600.12** | **336,482,691.49** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,981,800.12 | 24,749,091.49 |
| 210302 | Түлш, халаалт | 152,182,800.00 | 307,557,600.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,377,000.00 | 4,176,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **35,963,814.22** | **43,746,891.34** |
| 210401 | Бичиг хэрэг | 13,090,240.00 | 14,599,010.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 22,873,574.22 | 29,147,881.34 |
| **2105** | **Нормативт зардал** | 39,087,149.00 | 36,030,070.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 25,600.00 | |
| 210502 | Хоол, хүнс | 39,061,549.00 | 36,030,070.80 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,741,100.00** | **11,165,330.35** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,441,100.00 | 2,928,000.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээ | 3,300,000.00 | 8,237,330.35 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **240,386,917.90** | **239,841,546.43** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,620,778.00 | 19,633,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 80,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 224,766,139.90 | 220,127,846.43 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **53,129,674.88** | **49,266,161.51** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 46,256,675.00 | 49,169,973.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал | 46,256,675.00 | 49,169,973.00 |
| **2134** | **Орон нутгийн төвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт** | 6,872,999.88 | 96,188.51 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,872,999.88 | 96,188.51 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(199,125,676.34)** | **116,390,092.42** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **568,054,476.40** | **156,434,982.00** |
| **14** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО** | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 568,054,476.40 | 156,434,982.00 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал | 568,054,476.40 | 156,434,982.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(767,180,152.74)** | **(40,044,889.58)** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,230,770,300.00** | **2,022,837,848.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | 10,212,348.00 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 10,212,348.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | | 2,928,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | | 7,284,348.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,230,770,300.00** | **2,012,625,500.00** |
| | | **1,032,603,600.00** | **1,671,046,700.00** |
| **1311** | Нэмэлт санхүүжилтийн орлого | 14,252,100.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,469,100.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 7,793,000.00 | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 183,914,600.00 | 341,578,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/ | 183,914,600.00 | 341,578,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,243,796,513.32** | **1,896,794,322.41** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,243,796,513.32** | **1,896,794,322.41** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,192,050,193.44** | **1,850,448,614.90** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 791,456,356.86 | 1,224,161,797.53 |
| 210101 | Үндсэн цалин | 572,991,482.34 | 783,332,353.29 |
| 210102 | Нэмэгдэл | 182,963,416.52 | 393,067,285.67 |
| 210103 | Урамшуулал | 35,501,458.00 | 47,762,158.57 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **100,173,519.46** | **153,135,870.73** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 69,100,713.18 | 104,433,039.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,036,769.40 | 12,242,480.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,559,016.22 | 6,019,719.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,537,397.47 | 6,049,803.78 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,939,623.19 | 24,390,827.67 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **175,541,600.12** | **336,482,691.49** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,981,800.12 | 24,749,091.49 |
| 210302 | Түлш, халаалт | 152,182,800.00 | 307,557,600.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,377,000.00 | 4,176,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **41,617,329.00** | **37,778,299.80** |
| 210502 | Хоол хүнс | 41,617,329.00 | 37,778,299.80 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,500,000.00** | **4,999,920.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,500,000.00 | 4,999,920.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,741,100.00** | **11,165,330.35** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,441,100.00 | 2,928,000.00 |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 3,300,000.00 | 8,237,330.35 |
| 210807 | Газрын төлбөр | | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **75,020,288.00** | **82,724,705.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 64,498,998.00 | 70,110,935.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,521,290.00 | 12,613,770.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **51,746,319.88** | **46,345,707.51** |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 44,873,320.00 | 46,249,519.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал | 44,873,320.00 | 46,249,519.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **6,872,999.88** | **96,188.51** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,872,999.88 | 96,188.51 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(13,026,213.32)** | **126,043,525.59** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (13,026,213.32) | 126,043,525.59 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 125,784,391.21 | 112,758,177.89 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 112,758,177.89 | 238,801,703.48 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/төгрөгөөр/**

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **521,977,813.50** | **1,426,196,332.51** | **6,442,943,869.51** | **8,391,118,015.52** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **521,977,813.50** | **1,426,196,332.51** | **6,442,943,869.51** | **8,391,118,015.52** |
| Тайлант үеийн үр дүн | | | (40,044,889.58) | (40,044,889.58) |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **521,977,813.50** | **1,426,196,332.51** | **6,402,898,979.93** | **8,351,073,125.94** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн үзүүлэлт | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,131,183,500.00** | **1,896,698,133.90** | **234,485,366.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,074,019,900.00** | **1,850,448,614.90** | **223,571,285.10** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,379,693,600.00** | **1,224,161,797.53** | **155,531,802.47** |
| 210101 | Үндсэн цалин | 887,212,200.00 | 783,332,353.29 | 103,879,846.71 |
| 210102 | Нэмэгдэл | 475,892,300.00 | 393,067,285.67 | 82,825,014.33 |
| 210104 | Урамшуулал | 16,589,100.00 | 47,762,158.57 | (31,173,058.57) |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **172,461,600.00** | **153,135,870.73** | **19,325,729.27** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 117,273,900.00 | 104,433,039.39 | 12,840,860.61 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,796,900.00 | 12,242,480.08 | 1,554,419.92 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,898,500.00 | 6,019,719.81 | 878,780.19 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,898,500.00 | 6,049,803.78 | 848,696.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,593,800.00 | 24,390,827.67 | 3,202,972.33 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **336,578,800.00** | **336,482,691.49** | **96,108.51** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 24,845,200.00 | 24,749,091.49 | 96,108.51 |
| 210302 | Түлш, халаалт | 307,557,600.00 | 307,557,600.00 | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,176,000.00 | 4,176,000.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **59,008,300.00** | **37,778,299.80** | **21,230,000.20** |
| 210502 | Хоол, хүнс | 59,008,300.00 | 37,778,299.80 | 21,230,000.20 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,000,000.00** | **4,999,920.00** | **80.00** |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 4,999,920.00 | 80.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **35,236,200.00** | **11,165,330.35** | **24,070,869.65** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,928,000.00 | 2,928,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 32,308,200.00 | 8,237,330.35 | 24,070,869.65 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **86,041,400.00** | **82,724,705.00** | **3,316,695.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 73,427,500.00 | 70,110,935.00 | 3,316,565.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,613,900.00 | 12,613,770.00 | 130.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **57,163,600.00** | **46,249,519.00** | **10,914,081.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **57,163,600.00** | **46,249,519.00** | **10,914,081.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 57,163,600.00 | 46,249,519.00 | 10,914,081.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **112,758,177.89** | **(112,758,177.89)** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **238,897,891.99** | **(238,897,891.99)** |

### 2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **80112** | **Нийтлэг үйлчилгээ** | **341,578,800.00** | **341,482,611.49** | **96,188.51** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | **341,578,800.00** | **341,482,611.49** | **96,188.51** |
| **2103** | **БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ** | **336,578,800.00** | **336,482,691.49** | **96,108.51** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | **24,845,200.00** | **24,749,091.49** | **96,108.51** |
| 210302 | Түлш халаалт | 307,557,600.00 | 307,557,600.00 | **-** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,176,000.00 | 4,176,000.00 | **-** |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 4,999,920.00 | **80.00** |

## 2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 28.1 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс, аудитын явцад 28.1 сая төгрөгийн алдааг залруулсан.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

*Залруулсан алдаа:*

- Мөнгөн гүйлгээний тайланд өөрийн үйл ажиллагаанаас бий болгосон орлого 6.6 сая төгрөгийг 131105 кодтой дансанд бүртгэснийг 1200042 кодтой туслах үйл ажиллагааны орлого дансанд залруулж бүртгэснийг залруулав. Энэ нь УСНББОУС 01, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Бараа материалыг шууд зардалд 0.4 сая төгрөг бүртгэснийг бараа материалд орлого болгосон тусгаж залрууллаа. Энэ нь УСНББОУС 01, толилуулах батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Монголын цахилгаан холбоотой байгуулсан утасгүй интернэтийн 21.2 төлбөрийг шууд зардалд бүртгэж тайлагнасныг хөрөнгөөр бүртгэсэн. Энэ нь УСНББОУС 01, толилуулах батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 108.1 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс 0.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 107.1 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 0.8 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

**2.1 Албан шаардлага**

1. Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогч, няравт тус бүр 150.0 хувиар тооцон 3.8 сая төгрөгийг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчин Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор тогтоосон урамшууллын хэмжээг хэтрүүлэн олгосон, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Ажилтанд цалин дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, Төсвийн ерөнхий ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан балансын гаргалт, тооллого тооцоо, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг өөрийн болон харьяа байгууллагадаа байнга шалган зааварчилж байх гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.
3. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу чанартай зохион байгуулаагүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулаагүй, ашиг сонирхлын зөрчилгүй маягт бөглөөгүй, гэрээний нийт үнэ, нийлүүлэх бүтээгдэхүүний жагсаалт хавсаргаагүй гэрээг дүгнэж акт үйлдээгүй нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23-т "Худалдан авах ажиллагаа" гэж бараа худалдан авах, түрээслэх, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ авах ажиллагааг төлөвлөх, тендер шалгаруулалтын аргыг сонгох, үнэлгээний хороо байгуулах, тендер шалгаруулалт зохион байгуулах, тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх ажиллагааг", ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 39 дугаар зүйлийн 39.3.2-т “Гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл”, 48 дугаар зүйлийн 48.2.9-д “Энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах, 47.3-д “Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. НДШ-ийн тайлантай холбоотой

**Илрүүлэлт:** НДШ-ийн тайланд цалинг 0.8 сая төгрөгөөр дутуу тайлагнасан. Энэ нь УСНББОУС 01, нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** НДШ-ийн тайлан, Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн систем дэх ажил мэргэжлийн кодыг тулган ижил болгох.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мөнгөн гүйлгээний тайланд өөрийн үйл ажиллагаанаас бий болгосон орлого 6.6 сая төгрөгийг 131105 кодтой дансанд бүртгэснийг 1200042 кодтой туслах үйл ажиллагааны орлого дансанд бүртгэсэн | 1 | 6,612.7 | | | | | 1 | 6,612.7 | | | | |
| Бараа материалын 0.4 сая төгрөгийг орлогод авалгүй шууд зардалд бүртгэсэн. | 1 | 388.0 | | | | | 1 | 3,88.0 | | | | |
| Монголын цахилгаан холбоотой байгуулсан утасгүй интернэтийн 21.2 сая төгрөгийн төлбөрийг шууд зардалд бүртгэж тайлагнасан | 1 | 21,160.5 | | | | | 1 | 21,160.5 | | | | |
| **Дүн** | **3** | **28,161.2** | | | | | **3** | **28,161.2** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогчид 100 хувь, няравт 60.0 хувиар тооцон 2.2 сая төгрөгийг олгосон | 1 | 3,769.5 | | | 1 | 3,769.5 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ажилтанд цалин дутуу олгосон | 1 | 173.6 | 1 | 173.6 | | | | | | | | |
| Худалдан авалтын үйл ажиллагаа хангалтгүй, гэрээ байгуулсан огноо, дугаар, бараа бүтээгдэхүүн нийлүүлэх хугацаа алдаатай тусгагдсан байна. Гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй | 1 | 103,317.3 | | | 1 | 103,317.3 | | | | | | |
| НДШ-ийн тайланд цалинг 0.8 сая төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 840.0 | | | | | 1 | 840.0 | | | | |
| **Дүн** | **4** | **108,100.4** | **1** | **173.6** | **2** | **107,086.8** | **1** | **840.0** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 55.0 сая төгрөгийн 1 гүйлгээний мэдээллийг ил тод байршуулаагүй байна. | 1 | 55.000.0 | | | | | 1 | 55.000.0 |
| **Нийт дүн** | **1** | **55.000.0** | | | | | **1** | **55.000.0** |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 139/19625799 ДОА-2025/0821/ЧА-СТА-ПЕЗ Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогчид 1-1.5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 3,769,500.00 төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн *6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн *15.1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;* Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д *"Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна"* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.6 дах *"Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан"*,4.2.1.11 дэх *"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040350

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Халхгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Урантогос, нягтлан бодогч П.Оюунтулга нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НАНДИНЧИМЭГ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 140/19828799 Чойбалсан хот
ДОА-2025/1082/-НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа худалдан авах ажиллагааг хуулийн дагуу чанартай зохион байгуулаагүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулаагүй, ашиг сонирхлын зөрчилгүй маягтыг бөглөөгүй, гэрээний нийт үнэ болон нийлүүлэх бүтээгдэхүүний жагсаалт хавсаргаагүй 103,317,300.00 /нэг зуун гурван сая гурван зуун арван долоон мянга гурван зуун/ төгрөгийн гэрээг дүгнэж акт үйлдээгүй.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх” зарчим, 48 дугаар зүйлийн 48.2.7-т “Худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх”, 48.2.9-т “Энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах”, 47.3-т “Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.9 дэх *“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол”* , 4.2.1.11 дэх *”хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу хийж, гэрээний биелэлтийг үнэн зөв дүгнэж байх , биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040352

2. Хууль эрх зүйн шийдвэрийг  баримтлан ажиллахыг Халхгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал  Д.Урантогос, нягтлан бодогч П.Оюунтулга нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НАНДИНЧИМЭГ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 45/19125799 Чойбалсан хот
ДОА-2025/0821/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус сургуулийн ажилтан Т.Энхцэцэгийн цалин хөлсийг олгохдоо Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг мөрдөөгүй 173,631.20 төгрөг дутуу олгосон.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 2023 оны 06 дугаар сарын 21 ний өдрийн 240 дүгээр тогтоолоор баталсан "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-ын 3 дугаар хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д *"Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т *"цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"* гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" тогтоолын шаардлага хангахгүй болон дутуу олгосон 173,631.20 /нэг зуун далан гурван мянга зургаан зуун гучин нэгэн төгрөг хорин/ мөнгийг ажилтан Т.Энхцэцэгт нөхөн олгох.

2125050207

2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Халхгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Урантогос, нягтлан бодогч П.Оюунтулга нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

"ХААН КОНСАЛТИНГ АУДИТ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НАНДИНЧИМЭГ